



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ, ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ, №14

2017.07.31

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2017 оны 07-р сарын 16-аас 07-р сарын 31-ний хүртэлх хугацаанд Номхон далайн баруун бүсийн 4 оронд хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна. (Хүснэгт 1)

ХОЁР. 2003 оноос хойш бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл ба нас баралт:

2003 оноос 2017 оны 07-р сарын 31-ний хүртэлх хугацаанд дэлхийн 16 улсад шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусын **859** тохиолдол бүртгэгдсэнээс **453** (52.8%) нь нас барсан байна. 2003 оноос хойш Номхон далайн баруун бүсийн 4 оронд **238** тохиолдол бүртгэгдсэнээс **134** (56%) нь нас барсан байна. Камбожи улсад нас баралтын түвшин хамгийн өндөр (66%; 37/56) байна.

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2017 оны 07-р сарын 16-аас 07-р сарын 31-ний хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

2014 оны 5-р сараас хойш БНХАУ-д лаборатороор батлагдсан нийт **16** тохиолдлоос **6** (37.5%) нь нас барсан байна.

Хүснэгт 1. ДЭМБ-д мэдээлэгдсэн томуугийн А (H5N1) вирусын халдварын хүний өвчлөл, нас баралт, бодит тоогоор, 2003 – 2017.07.31

Улс	2003-2011		2012		2013		2014		2015		2016		2017		Нийт	
	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н
Камбожи	18	16	3	3	26	14	9	4	0	0	0	0	0	0	56	37
Хятад	41	27	2	1	2	2	2	0	6	1	0	0	0	0	53	31
Лаос	2	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	2	2
Вьетнам	119	59	4	2	2	1	2	2	0	0	0	0	0	0	127	64
Нийт	180	104	9	6	30	16	13	6	6	1	0	0	0	0	238	134

Тэмдэглэгээ: (Т)-тохиолдол; (Н)-нас баралт

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2017 оны 07-р сарын 16-аас 07-р сарын 31-ний хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн **(21) шинэ тохиолдол** Хятад улсын Anhui (1), Beijing (3), Guangxi (1), Guizhou (3), Hebei (1), Hunan (1), Jiangsu (1), Shanxi (1), Sichuan (2), Tianjin (1), Yunnan (4), Zhejiang (1), Inner Mongolia (1) мужуудад тус тус бүртгэгдсэн талаар Хятадын үндэсний эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн комиссоос мэдээлсэн байна.

Эдгээр 21 тохиолдлын 17 нь шувууны аж ахуй болон амьд шувууны захаас халдвар авсан бөгөөд 4 тохиолдлын эх уурхай тодорхойгүй. Бүх тохиолдлын 4 нь эмэгтэй, дундаж нас 48.6 (4-79 насныхан) байна.

2013 оноос хойш шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн нийт **1554** тохиолдол лаборатороор батлагдсан байна.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусын шувууны өвчлөлийн мэдээлэл:

2017.07.16 - 07.31

Тив	Улс	Өртөмхий	Өвчтэй	Үхсэн	Устгасан	Нядалсан	Өртөмхий зүйл
Ази	Мьянмар	5000	3194	3194	1806	0	Тахиа
	Нийт	5000	3194	3194	1806	0	-

Албан ёсны эх сурвалж:

- http://www.who.int/influenza/human_animal_interface/H5N1_cumulative_table_archives/en/index.html
- http://www.who.int/influenza/human_animal_interface/EN_GIP_20140727CumulativeNumber_H5N1cases.pdf
- http://www.wpro.who.int/outbreaks_emergencies/H7N9/en/index.html
- http://www.who.int/influenza/human_animal_interface/influenza_h7n9/en/index.m
- http://www.wpro.who.int/emerging_diseases/aiweekly_465_09jan2015.pdf?ua=1
- <http://empres-i.fao.org/eipws3g/#h=0>

ЗӨСҮТ

ЭУББТСТ

ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧИН ХАРИУЦСАН БАГ